


# Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл (ҮХЦТ)




Барилга, хот байгуулалтын яам  
/ Эдийн засаг, хөгжлийн яам

Японы Олон улсын  
хамтын ажиллагааны  
байгууллага



## Хөгжлийн шинэ загвар руу шилжих нь



RECS International Inc.  
PADECO Co., Ltd.  
Nippon Koei Co., Ltd.

Төслийн видео үзэх линк








## Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (ЖАЙКА) техникийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болох Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг (ҮХЦТ) боловсруулсан. ҮХЦТ-ний төлөвлөлт, саналыг Барилга, хот байгуулалтын яамны (БХБЯ) боловсруулж буй Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (ХАНСХЕТ) болон Үндэсний хөгжлийн газрын (ҮХГ) боловсруулж буй Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд (БХҮБ) тусгана. Нэгдсэн үндэстний байгууллагаас (НҮБ) санаачилсан дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгуудын (ТХЗ) хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (ТХҮБ) баримт бичгийг боловсруулан баталсан бөгөөд ТХҮБ 2030 баримт бичгийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд нь агуулгаараа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан. ҮХЦТ нь тус бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



ҮХЦТ-г төрийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил болон залуучуудын төлөөллийг оролцуулан олон нийтийн оролцоог хангаж, “сценари төлөвлөлт” хийх арга зүйд үндэслэн боловсруулсан. Оролцогч талуудын цуврал хурлуудыг зохион байгуулсан бөгөөд COVID-19 цар тахал дэгдсэний дараа тус хурлууд цахимаар явагдсан.



1990 онд Монгол Улс нь шинэ нийгэм, шинэ тогтолцоо руу шилжсэн. 2000-аад онд уул уурхайн салбарын хөгжлөөс хамааран улсын эдийн засаг өндөр өсөлтийг үзүүлсэн. ҮХЦТ-ний хүрээнд тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг хангах (нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбар) хөгжлийн шинэ загварыг санал болгож байна.



## Алсын хараа, үзэл баримтлал

Хөгжлийн шинэ загварт шилжин хөгжихийн тулд ҮХЦТ-ний хүрээнд нийгэм, эдийн засаг, орон зайн тэнцвэртэй хөгжлийг хангах бүсчилсэн хөгжлийг онцлон авч үзсэн. Монгол Улсын геополитикийн байршил болон байгаль, соёлын арвин баялаг зэрэг өвөрмөц онцлог, хурлын үеэр тодорхойлсон аз жаргалын ойлголтуудыг тусгаж, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны алсын харааг тодорхойлсон.

### Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн алсын хараа

Шинэ мэдлэг, боловсролоор өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг хүний нөөцтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, байгалийн болон соёлын баялаг нөөцийг ухаалгаар, зүй зохистой ашиглаж эдийн засаг, экспортыг төрөлжүүлэн, уян хатан нийгэм, эдийн засгийг хөгжүүлнэ.

Хөгжлийн алсын харааг хэрэгжүүлэхэд шаардлагатай Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах бүх оролцогч талуудын хүлээн зөвшөөрсөн нийтлэг ойлголт, үзэл баримтлалыг тодорхойлсон.

### Монгол Улсын үндэсний цогц хөгжлийг

- Олон хэл, соёлтой ястан угсаатан хамтран амьдрах
- Хүчирхэгжилтийн төлөөх нэгдмэл байдлыг хангах
- Нүүдлийн соёл, уламжлал бүхий харилцаа холбооны технологи нэвтрүүлэх
- Дэлхийн чиг хандлагад нийцсэн сайн засаглалыг бэхжүүлэх
- Хөрш орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Өрнө, Дорныг холбох, зохицуулах
- МХХТ-ийг нэвтрүүлсэн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн дэвшилтэт хувилбарыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан хангана.



## Хөгжлийн хувилбарууд

ҮХЦТ-ний хүрээнд хөгжлийн хувилбаруудыг боловсруулж, үнэлгээ хийсний үр дүнд экспортын бараа бүтээгдэхүүн болон эдийн засгийг төрөлжүүлэх өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжлийг хамгийн оновчтой хувилбараар сонгосон. Энэхүү хувилбараар 2040 онд ДНБ-ий жилийн дундаж өсөлт 7.1% байх бөгөөд нийт хүн ам 4.64 сая хүрнэ.

Хувилбар	Тодорхойлолт	ДНБ-ий өсөлт	
A	Уул уурхайд түшиглэсэн хөгжил	Эдийн засаг болон экспортын өсөлтийг хангахын тулд уул уурхайн салбараас хамааралтай хэвээр байна.	6.7%
B	Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил	Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл нь хөгжлийн гол хөдөлгөгч хүч болно.	6.7%
C	Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил	Үйлчилгээний салбарын өндөр өсөлтийг хангах Монгол Улсын транзит тээвэр нь хөгжлийн өөр нэг хөдөлгөгч хүч болно.	6.7%
D	Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил	Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл, транзит тээвэр нь эдийн засгийн өндөр өсөлтийг хангана.	7.1%

Салбар	Хувилбар D: жилийн дундаж өсөлт (%)
Хөдөө аж ахуй	3.5
Уул уурхай	5.0
Боловсруулах аж үйлдвэр, нийтийн аж ахуй	9.4
Үйлчилгээ	8.3
ДНБ	7.1









## Хотын зэрэглэл, газар зохион байгуулалтын тойм төлөвлөгөө

ҮХЦТ-ний хүрээнд Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн томоохон хотуудыг холбосон тойрог коридорыг байгуулж, хотуудын чиг үүргийг тодорхойлж, хотын зэрэглэлийг санал болгосон нь хот, хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг тэтгэх нутаг дэвсгэрийн орон зайн оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгоход хувь нэмэр оруулна. ҮХЦТ-ний хүрээнд газар зохион байгуулалтын тойм төлөвлөгөө боловсруулсан. Тариалангийн талбайг нэмэгдүүлж, эрчимжсэн суурин мал, амьтны аж ахуй эрхлэх бүс болон бэлчээр ашиглалтын хяналт бүхий газрыг тодорхойлж, ойн сан бүхий газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, улсын тусгай хамгаалалттай газарт усны тэжээгдлийн муж бүхий газар нутгийг оруулсан.

Орон зайн төлөвлөлт




Газар зохион байгуулалтын тойм төлөвлөгөө



## Эдийн засгийн шинэ бүсчлэл

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор ҮХЦТ-ний хүрээнд аймгуудын онцлог, ижил, төстэй байдлыг тодорхойлж, эдийн засгийн шинэ бүсчлэлийг санал болгосон. 21 аймгийг байгаль орчин, нийгэм, эдийг засаг, газар зохион байгуулалт, төсөв санхүү болон бусад нөхцөл байдлыг илэрхийлсэн 30 шалгуур үзүүлэлтийн дагуу харьцуулж, ижил, төстэй хөрш зэргэлдээ аймгуудыг бүлэг болгож эдийн засгийн шинэ бүсчлэлийг тогтоосон.

аймгуудын ижил төстэй байдлын



эдийн засгийн шинэ бүсчлэл




## Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр (БХНХ)

ҮХЦТ-нд бүсийн хөгжлийн алсын харааны хүрээнд тухайн бүс нутгийн нийгэм-эдийн засгийн онцлог, байгаль, соёлын нөөц, аймгуудын хөгжлийн чиг хандлагыг тусгаж, бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг (БХНХ) боловсруулсан.

Бүс	Алсын хараа	Бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт
Баруун бүс	Ногоон хөгжлийн загвар бүс болох	- Ховд-Улаангом-Өлгий хөдөө аж ахуйн коридор
Хангайн бүс	Нийгэм, эдийн засгийн цогц хөгжлийг хангасан бүс болох	- Дархан-Мөрөн худалдаа, аялал жуулчлалын коридор
Алтайн бүс	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлсэн, эрчим хүчний нөөц бүхий бүс болох	- Алтай-Баянхонгор-Арвай-хээр мал аж ахуй эрхлэх бүс - Хархорин-Орхоны хөндийн соёл, аялал жуулчлалын гурвалжин
Өмнөд бүс	Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлсэн, олон нийтийн хөгжлийн загвар болсон бүс болох	- Мандалговь-Чойр-Сайншандын логикийн коридор - Сайншанд-Замын-Үүд-Говийн аялал жуулчлалын гурвалжин
Зүүн бүс	Хөдөө аж ахуй-худалдаа-аялал жуулчлалыг хөгжүүлсэн хилийн бүс болох	- Чойбалсан-Баруун-Урт-Өндөрхааны хөдөө аж ахуйн нэгдсэн бүс
Нийслэлийн бүс	Дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, логикийн баазыг хөгжүүлсэн бүс болох	- Дагуул хотын хөгжил (Төв)

Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийг хөгжүүлэх хөтөлбөр







## Хөгжлийн хувилбар

ҮХЦТ-нд нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загвар руу шилжин, хөгжихөд дараах үе шат бүхий хөгжлийн хувилбарыг тодорхойлж, санал болгосон.

I үе шат: 2025 он хүртэл	II үе шат: 2026-2030 он	III үе шат: 2031-2040 он
<p><b>Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварт шилжин, хөгжих бэлтгэл үе шат</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Капиталыг хуримтлуулах;</li> <li>- Эдийн засгийн шинэ үйл ажиллагаануудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийх;</li> <li>- Нутгийн захиргааны байгууллагын чадавхыг тогтвортой бэхжүүлэх;</li> <li>- Бүх салбарт дижитал шилжилтийг хурдацтай нэвтрүүлэх.</li> </ul>	<p><b>Нийгэм, эдийн засгийн бүтцийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварт тохируулан өөрчлөх ажил идэвхтэй хийгдэх үе шат</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн удирдлагын хөгжлийн зарим чиг үүргийг, байгаль орчны хяналт, менежментээс эхлүүлэн нутгийн удирдлагын байгууллагуудад шилжүүлэх;</li> <li>- Орон нутгийн нийгмийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх хамтын ажиллагааны механизмыг институцилэх.</li> </ul>	<p><b>Монгол Улс нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангасан шинэ загварт бүрэн шилжсэн байх үе шат</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ТХЗ, “Алсын хараа 2050” -ын хэрэгжилтийг дүгнэж, хөгжлийн стратеги, тэргүүлэх чиглэлүүдийн өөрчилж, шинэчлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлох;</li> <li>- ОХУ, БНХАУ, бусад улс, орнуудтай худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх;</li> <li>- Төрийн зарим чиг үүргийг нутгийн удирдлагын байгууллагуудад үе шаттайгаар шилжүүлэх, хуваарилах үйл ажиллагааг үргэлжлүүлэх.</li> </ul>


ҮХЦТ-нд бодлогын зорилгыг тодорхой болгох, төсөл, хөтөлбөрүүдийг уялдуулан хэрэгжүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрүүдийг дараах байдлаар дөрөв ангилсан.

Төсөл, хөтөлбөрүүд	Зорилго
Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд	Гадагш чиглэсэн хөгжлийн бодлогын хүрээнд эдийн засаг, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх
Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд	Боловсрол, сургалтаар дамжуулан хөгжлийн шинэ загвар руу шилжин хөгжихөд иргэдийг чадавхжуулах
Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд	Авто замын гол, дэд тэнхлэгүүдийн сүлжээг өндөр түвшинд төлөвлөж, сонгогдсон хот, суурин газруудын чиг үүргийг шинэчилж Монгол Улсын нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтыг бэхжүүлэх
Ногоон хөгжлийг дэмжих төслүүд	Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах



## Хөгжлийн стратеги

ҮХЦТ-ний хөгжлийн стратегид аж үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, орон зайн төлөвлөлт, бүтцийг бэхжүүлэх, МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх үйл ажиллагааг онцолсон. Үүний жишээ нь тээвэр, харилцаа холбооны сүлжээг хөгжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластер юм.



ҮХЦТ-нд Засгийн газрын удирдлага, санаачилга дор хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргээс эхлэн хөгжлийн удирдлагын чиг үүргийг орон нутгийн удирдлагад үе шаттайгаар шилжүүлэх үйл ажиллагааг санал болгосон. Үүний хүрээнд эдийн засгийн бүс бүрт Бүсийн хөгжлийн зөвлөлийг (БХЗ) байгуулж, бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг (БХНХ) хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх саналыг боловсруулсан.

## ҮХЦТ-ний гол төсөл, хөтөлбөрүүд

Хөгжлийн санал, төлөвлөлт бүрт гол төсөл, хөтөлбөрийг санал болгосон ба Монгол Улсын нийгэм-эдийн засаг, орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд		Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд	
I 1.1	Хилийн Чөлөөт худалдааны бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл	III 1	Авто замын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл
I 2	Аж үйлдвэрийн кластеруудыг дэмжих хөтөлбөрүүд	III 2	Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл
I 2.2	МАН-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл	III 4	Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл
I 3.2	Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл	III 5	Хойд-өмнөд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл
I 3.3	Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төсөл	III 9	Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах төсөл
I 4.2	Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх төсөл	Ногоон хөгжлийг дэмжих төслүүд	
I 5.3	Чацарганы тариалалтын төсөл	IV 2.2	Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл
I 7.2	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл	IV 2.4	Эко-парк байгуулах төсөл
I 9.1	Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл	IV 3.1	Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл
I 10.2	“Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл	IV 3.2	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл
Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд		IV 6	Туул голд усан цогцолбор байгуулах төсөл
II 1.1	Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл	IV 7.1	Хот, суурины ус хангамжийг сайжруулах төсөл
II 2.1	Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл	IV 8.4	Сумын төвд бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл
II 3	Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл	IV 9	Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл
II 4	Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр		
II 6	Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл		
II 7.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл		
II 9.1	Бүлгийн динамикийн төв байгуулах төсөл		

